



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 4/630

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд, өсвөр үеийнхний дунд зохион байгуулагддаг соёл, спортын үйл ажиллагаа, бусад арга хэмжээний 2025 оны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч талууд, арга хэмжээ зохион байгуулагч хуулийн этгээдийн саналд үндэслэн, хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц үр дүнтэй ажил, арга хэмжээг нэгтгэн төлөвлөж, төлөвлөгөөг салбар зөвлөлийн IV хуралдаанд хэлэлцүүлэн батлуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн Засаг даргын 2024
оны....дүгээр сарын....-ний өдрийн
....-р захирамжийн хавсралт

ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ
СОЁЛ, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БУСАД АРГА ХЭМЖЭЭНИЙ
2025 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цэцэгмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)

Гишүүд:

О.Бадраа (Аймгийн Боловсролын газрын дарга)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Б.Очирбат (Аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Б.Мөнхнаран (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн дэд тэргүүн)

А.Сарангуа (Аймгийн Хүүхдийн зөвлөлийн нарийн бичиг)

Нарийн бичгийн дарга:

Ч.Дашбаяр (Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга,
хүүхдийн эрхийн улсын ахлах байцаагч)

_____оОо_____